

## **Орон нутгийн 2017 оны тодотгосон төсөв боловсруулж, батлуулахад баримтлах зарчим:**

### **1. Төсвийн урсгал зардлын талаар:**

Монгол Улсын Их Хурлаас нэгдсэн төсвийн урсгал зардлыг 2017 оны батлагдсан түвшнээс 104.4 тэрбум төгрөгөөр бууруулж баталлаа. Урсгал зардлын бууралтын дийлэнх хэсгийг зээлийн үйлчилгээний төлбөр бүрдүүлж байна.

Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын 2017 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн тогтоолыг хэрэгжүүлэх чиглэлээр дараах зүйлсийг анхаарч ажиллах шаардлагатай байна. Үүнд:

1.1 Төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2017-2018 онд одоогийн түвшинд хэвээр хадгалах, цалин хөлс цаашид нэмэх асуудлыг 2019 оноос төсвийн боломжтой уялдуулан шийдвэрлэх, орон тооны хязгаарлалтын горим тогтоон мөрдүүлэхээр УИХ-аас Засгийн газарт чиглэл өгсөнтэй холбогдуулан орон нутгийн нийт суурь зарлагаас 0.2 тэрбум төгрөг, улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох тусгай зориулалтын шилжүүлгээс 1.4 тэрбум төгрөгийг тус тус бууруулсан тул дараахь арга хэмжээг хэрэгжүүлэх:

а/ төрийн албан хаагчид зэрэг, дэв олгох буюу зэрэг, дэв ахиулах шийдвэрийг 2017-2019 онд гаргахгүй байх;

б/ төрийн албан хаагчийн албан тушаалын зэрэглэл, шатлалыг ахиулахыг 2017-2019 онд түр зогсоох талаар орон нутгийн засаг захиргааны болон тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүждэг төсөвт байгууллагын төсвийн шууд захирагч нарт үүрэг болгох;

в/ 2017-2019 онд зөвхөн эрүүл мэнд, боловсролын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагаас хоёр албан хаагч чөлөөлөгдсөн тохиолдолд нэг албан хаагчийг (2:1) нөхөн томилох, бусад бүх салбарт нөхөн томилгоо хийхгүйгээр ажилтны ажил, үүргийн хуваарийг шинэчлэн оновчтой тогтоох замаар ачааллыг нягтруулах, хэрэв зайлшгүй шаардлагатай орон тоог нөхөн томилох шаардлагатай гэж үзвэл төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад дахин зохион байгуулалт хийх зарчмаар шийдвэрлэх арга хэмжээг зохион байгуулах;

1.2 Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсанаар тэтгэврийн даатгалын шимтгэлийн хэмжээг 2018 оноос эхлэн гурван жилийн хугацаанд ажил олгогч болон даатгуулагч тус бүр 1.0, 0.5, 1.0 нэгжээр нэмэгдсэн. Тухайлбал, Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх тэтгэврийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ 2017 онд тус бүр 7.0 хувь, 2018 онд тус бүр 8.0 хувь, 2019 онд тус бүр 8.5 хувь, 2020 оноос эхлэн тус бүр 9.5 хувьтай байна. Харин Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан сайн дураар даатгуулагчийн тэтгэврийн даатгалд сард төлбөл зохих шимтгэлийн доод хэмжээ нь 2017 онд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 10.0 хувиас, 2018 онд 11.0 хувиас, 2019 онд 11.5 хувиас, 2020 оноос эхлэн 12.5 хувиас багагүй байна.

## **2. Үндсэн тэнцлийн ашгаас дээд шатны төсөвт төвлөрүүлэх хувь:**

Төсвийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.1, 56.2.2-д зааснаар үндсэн тэнцлийн ашгаас орон нутагт 70 хувийг үлдээж байсан зохицуулалтыг 2017 онд 60 хувь, 2018 онд 40 хувь болгон бууруулсан бөгөөд 2019 онд 60 хувь, 2020 оноос хойш дахин 70 хувь болгон нэмэгдүүлэх өөрчлөлт орсон болно. Үүнтэй холбоотойгоор үндсэн тэнцлийн ашигтай аймгуудаас 2017 онд улсын төсөвт төвлөрүүлэх дүн 73.7 тэрбум төгрөгөөр нэмэгдэж нийт 206.3 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр болсон байна.

## **3. Орон нутгийн хөгжлийн сан**

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн тооцооллыг боловсруулахдаа “Төсвийн тухай хууль”, Засгийн газрын 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох орлогын шилжүүлэг тооцох аргачлал”-ыг тус тус үндэслэл болгосон.

2017 оны ОНХС-ийн эх үүсвэрт орсон өөрчлөлтүүд:

### **➤ (АМНАТ – Мега төсөл)\*10 хувь:**

Төсвийн тухай хуулийн 60.2.6. заасны дагуу нийт АМНАТ-ийн орлогоос улсын чанартай томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэгч хуулийн этгээдийн төлсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн орлогыг хассан зөрүүний 10 хувийг тухайн орлогыг төвлөрүүлсэн аймаг, нийслэлд нь нэмж хуваарилаж байгаа 60.7-д заасан хуулийн зохицуулалтыг 2020 оны төсвийн жил хүртэл хойшлуулсан. Төсвийн тухай хуулийн 60.2.6-д заасан эх үүсвэр нь мөн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2-т заасан эх үүсвэрээс давхардуулан хуваарилаж байсан зохицуулалт юм.

### **➤ Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50 хувь:**

Төсвийн тухай хуулийн 60.2.7-д заасан эх үүсвэрийг энэхүү орлогыг төвлөрүүлсэн тухайн аймаг, нийслэлд Улсын төсвөөс хуваарилах 60.7 дах заалтыг 2020 он хүртэл хойшлуулсан.

Төсвийн тухай хуульд орсон эдгээр өөрчлөлтөөр ОНХС-ийн 2017 оны батлагдсан дүн 28.6 тэрбум төгрөгөөр буурсан боловч олон улсын төсөл хөтөлбөрөөс олгох /Тогтвортой Амьжиргаа-3 төсөл/ гүйцэтгэлд суурилсан урамшуулалаар 7.1 тэрбум төгрөг нэмэгдэж 2017 оны тодотгосон төсвөөр аймаг, нийслэлд олгох орлонын шилжүүлгийн дүн 53.0 тэрбум төгрөг болсон.

### **➤ Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив:**

Төсвийн тухай хуулийн 59.1.3 болон 60.2.5 дах заалт нь “Орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор олгосон дотоодын төрийн бус байгууллагын болон гадаадын албан ёсны тусламж, хандив, дээд шатны байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрөөс олгох урамшуулал, дэмжлэг;” гэж өөрчлөгдсөн. Үүнтэй холбоотойгоор дараах нэмэлт заалтыг оруулсан. Үүнд:

“59.2.4 Энэ хуулийн 59.1.3, 60.2.5-д заасан эх үүсвэрийг хандивлагч талаас болон урамшуулал, дэмжлэг олгогч байгууллагаас хүлээн авагч талыг тусгайлан заасан тохиолдолд тухайн сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд шууд хуваарилах ба итгэлцүүрээр хуваарилах хөрөнгөд тооцохгүй.”

Иймд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас аймаг, нийслэлийн ОНХС-д хуваарилагдсан дүнгээс сум, дүүргийн ОНХС-д хуваарилахдаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

- ОНХС-аас санхүүжих суурь зардлыг батлагдсан дүнгээр тухайн зардал ногдох сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн санд мөн Тогтвортой амьжиргаа-3 төслөөс урамшуулал хүлээн авах сумын ОНХС-д хавсралтад заасан дүнг шууд хуваарилна.

- Нийт хуваарилагдсан дүнгээс суурь зардал болон урамшууллын дүнг хасаж үлдсэн хэсгийг бүх сумдын /дүүргийн/ ОНХС-д хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээнээс хамааруулан хуваарилна. Өөрөөр хэлбэл урамшуулал, хүлээн авсан сумд болон суурь зардал тооцогдсон сумдыг итгэлцүүрт хамруулах бөгөөд энэхүү урамшуулал болон суурь зардал нь тухайн сумын ОНХС-д хуваарилагдах хөрөнгийг бууруулах үндэслэл болохгүй гэдгийг анхаарна уу.

Мөн энэхүү урамшуулалыг ОНХС-ийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхэд буюу холбогдох журам, зааврын дагуу зарцуулна.